

ЯЛЫН ТУХАЙ ГҮН УХААН, ЭРХ ЗҮЙ, ШАШИНЫ СУРГААЛ, НОМЛОЛЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ PHILOSOPHY OF SENTENCES, IT'S LAW, REGION, THEOLOGY AND DEVELOPMENT



С.Жанцан. ХСИС-ийн Шинжлэх ухаан, технологийн газрын Цагдаа судлалын төвийн дарга бөгөөд Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа

Jantsan.S. Chief of the Police studies center and Leading scientific researcher, Science and Technology Department, Law Enforcement University, Honored lawyer of Mongolia, Sc.D, Professor, Police Colonel

Abstract: The special type of state duress is sentences, its forms, philosophy, law, region, theology and development are presented comparatively in the past, present and future times.

Эртний Египетийн улс төр, эрх зүйн сэтгэлгээ нь нийгэм баян ба доодост хуваагдсаныг зөвтгөж нэг бичмэл сургаалд "...хааны эсрэг босон тэмцэгчид ба өмч хөрөнгөнд халдагсдыг хайр найргүй хяргаж нух (ял шийтгэ С.Ж)"²⁵, Эртний Египетийн зарим дурсгал бичигт энгийн ард олон, доодсын хүсэл мөрөөдөл, санаа сэтгэлийг илэрхийлсэн нь олонтаа байдаг. Тухайлбал, нэг тариачин эр бусдад дээрэмдүүлж шүүгчид гомдоллосон боловч шүүгч шударгаар хандаагүй учраас шүүхийн даргад хандаж "Та шүүхийн албыг муу гүйцэтгэж байна. Таны гар хүчирхийлж, зүрх сэтгэл чинь ховдоглон шунаж байна... Улс оронд аюулгүй байдал алга... Чи үнэнийг сонсож шударгаар шүүх, дээрэм, тонуулыг хазаарлан зогсоох үүрэгтэй атал хулгайч дээрэмчинтэй нэгдэж нийлжээ.

Шүүгч та дээрэмчнийг хазаарлаж чөдөрлөх, сул дорой доодсыг хамгаалах ёстой... Шүүгч та худал бүү хэл, нүгэл ба буян, шударга ба шударга бусыг шүүн хэмжигч, дэнс жигнүүр мөн. Таны үг яриа бол жинлүүрийг заагч сум, таны зүрх сэтгэл бол жингийн туухай, таны хэл ам бол жинлүүрийн тэнхлэг тэгнүүр юм шүү дээ. Хэрэв та хүчтэнийг хараад нүүр нүдээ гараараа таглах юм бол хүчирхийлэл, гэмт хэргийг хэн хазаарлаж зогсоох юм бэ? Гэтэл та зөвхөн мөнгөтэй хүнийг л гол гаталган гаргадаг гаталгагч шиг болжээ. Та номхон бор шувуугаар (ядуу доод хүмүүс С.Ж) хооллогч махчин шувуу юм" гэх зэргээр

²⁵ Вестник древней истории. 1950 №2. 126-127 дахь тал

хурц үг шударга шүүмжээр дайрч байгаа тухай эртний Египетийн номлолд гардаг²⁶

Вавилоны улс төрийн сэтгэлгээ эрх зүйн үзэл номлолтой нягт уялдаатайгаар төлөвшиж хөгжсөн харагддаг. Тухайлбал, Хаммурапи хааны хуульд нийгмийн дэг журам, төрийн шийдвэрийг нэг мөр хэрэгжүүлэхэд хууль цааз, эрх зүйн хэм хэмжээ хамгаас чухал болохыг заадаг байв. Энэ хуулийн оршил хэсэгт хууль цаазын зорилго бол "улс оронд шударга ёсыг тогтоох, хууль зөрчигчид, нүгэлтэй муу явдалтангуудыг хөнөөж устгах, хүчтэй нь дорой буурайгаа шахаж дарангуйлахгүй болгох явдал"²⁷ гэжээ.

Вавилоны улс төр, эрх зүйн сэтгэлгээнд нийгмийн янз бүрийн анги, бүлгүүдийн байр суурь, эрх ашгийг ямар нэг хэмжээгээр хамгаалж, тэгш байдал, шударга ёсыг бэхжүүлэх нь нийгэм бүхэлдээ тогтвортой тайван, нэгдмэл, бүрэн бүтэн байх, эзэн хааны түшиг тулгуур өргөжин бэхжихэд ач тустай гэсэн тэргүүний үзэл санаа гарч байв.

Эртний Иран улсын төр эрх зүйн сэтгэлгээний өв болсон "Авеста" хэмээх сударт хүмүүс буяныг эрхэмлэж, нүглийн эсрэг тэмцэх ёстой бөгөөд үүний тулд:

- а/ сайнаар бодох буюу зөв санаатай байх
- б/ сайнаар үнэлэх буюу зөв үгтэй байх

²⁶ История политических и правовых учении Древний мир. М.,1965. 80 дахь тал

²⁷ Крестоматия по истории Древнего Востока. М.,1963. 196 дахь тал

в/ сайнаар үйлдэх буюу зөв үйл гэсэн гурван зарчмыг баримтлах тухай заажээ.

Эдгээр зарчмын дагуу нийгмийн дэг журам, ёс заншил, хууль ёсыг чанд мөрдөх нь сүсэгтэн олны ариун үүрэг гэж үздэг.

Энэ сударт гэмт хэрэг, ялын талаар тодорхой заасан. Тухайлбал, ямарваа буруу үйл хийсэн хэн боловч бурхны цээрлэл, ял зэм хүртэх ёстой бөгөөд энэ бол шударга ёсны биелэл гэж үзэж байв.

Эртний Энэтхэгт зөв зүйтэй зам мөр, үйл ажиллагааны хэм хэмжээ, дүрэм журмыг багтаасан “Карма” хэмээх гол сургаалыг /номлолыг/ мөрдөхийн зэрэгцээ төрийн хүчтэй засаглал, хүчирхийлэл, албадлага, шийтгэл зайлшгүй чухал гэдгийг бодитойгоор ойлгосны илэрхийлэл болсон “Данда” хэмээх ойлголт үүсч, улмаар “Ману”-ийн хуульд энэ сургаал тусч, данда нь эзэн хааны очирт таяг, саваа, гадас, гэмт хэрэгтнийг хүлэх багана, зэвсэгт хүч, цэрэг арми гэсэн утгыг илэрхийлэх болжээ. Гэхдээ “Данда”-ийн хамгийн гол шууд утга нь **шийтгэл, залхаан цээрлүүлэлт** юм. Энэтхэгийн сурвалж бичгүүдэд “Данданиа” гэсэн үг гарч байгаа нь ял шийтгэлийг хэрэглэх ухаан, шийтгэх урлаг гэсэн утгатай байжээ. Данда бол эзэн хааны засаглалыг хэрэгжүүлэхэд туслах зорилготой тэнгэр бурхны хөвүүн ажээ. Данда буюу шийтгэл, албадлага, хүчирхийллийг гэмт хэрэг, түүний хор уршиг, хүнд хөнгөний хэр хэмжээнд нь тохируулж шударга байдлаар хэрэглэх ёстой бөгөөд нэг ёсондоо урлаг ухаан гэсэн үзэл санаа гарч байгаа юм. Энэ утгаараа Данда бол нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх чухал хэрэгсэл, баталгаа юм.²⁸

Эртний Энэтхэгийн улс төр, эрх зүйн сэтгэлгээний нэг том чиглэл бол **Брахманизм** юм. Брахманизм бол хүн ардыг эрх чөлөөтэй варнууд, мөн эрх чөлөөгүй боолуудад хуваасан байдаг. “Брахман” болон “Кшатри” /цэрэг дайчид/ нийгэмд ноёрхогч байр суурьтай, “шудр” бол ядуу доодос бөгөөд тэд брахманд захирагдах ёстой. Брахманизмын сургаал ёсоор хүн бүр бурхан, тэдгээрээс тогтоосон хууль, ариун үүрэг болох дхарматай бөгөөд түүний шаардлагыг үнэнч шударгаар сахиж биелүүлэх ёстой. Түүнийг зөрчих нь гэм нүгэл /гэмт хэрэг/ бөгөөд түүний төлөө насандаа шийтгэл цээрлэл хүлээнэ.

Брахманизмын улс төр, эрх зүйн сургаал боловсрогдон төрийг жолоодох ухаан, урлагийн түвшинд хүрсэн байж. Төрийн хүчирхийлэл, шийтгэлийн тухай брахманизмын сургаалын гол үзэл санаа нь “...хамаг ертөнц зөвхөн шийтгэлийн сүр хүчинд л захирагдана” гэж товч тодорхой санаатайгаар илэрхийлэгджээ.

Хүн бол угаасаа гэм нүгэл үйлдэмтгий амьтан бөгөөд тэр чанарыг нь хазаарлаж дарж чадах, буяны замаар хөтлөх хамгийн чухал, хүчирхэг хэрэгсэл бол **ял шийтгэл**, цээрлэл мөн гэж брахманизм үздэг.

²⁸ А.Жамбал. Улс төрийн сургаалын түүх /эртний үе/. УБ.,2001. 90-91 дэх тал

Өөрөөр хэлбэл, нийгэм түүний зохион байгуулалт, дэг журам бол төрийн албадлага, шийтгэл дээр тогтож бэхжинэ. Төрийн удирдлага гэдэг бол угтаа албадлага ял шийтгэлийг зөв зүйтэй, оновчтой хэрэгжүүлэх урлаг, ухаан юм. Эртний Энэтхэгт ял шийтгэлийг Данда хэмээх ойлголтоор илэрхийлдэг бөгөөд Данда нь угтаа бурхан тэнгэрийн хөвүүн бөгөөд газар дэлхий, нийгэмд бууж залрахдаа гэм нүгэл үйлдэгсдийг зодож жанчих, саваа модны төрх байдалтай байв.

МЭӨ VI зуунд гарч ирсэн шашин, үзэл суртлын шинэ урсгал бол **Буддизм** юм. Буддизмыг Бурхан Будда хэмээх бодит үндэслэсэн гэж үздэг. Буддизмын сургаал ёсоор нүгэл нь сувдаг шунахай сэтгэлийн үр дагавар бол хулгай, дээрэм, худал хуурмаг явдал, ийм муу явдалтай тэмцэх хэрэгсэл болж ял зэмлэл, хүчирхийлэл үүссэн гэж үздэг. Буддын эрх зүйн үзлээр бол нийгэмд оршин буй нүгэл болох гэмт хэрэгтэй тэмцэхдээ хүч хэрэглэж болохгүй. “... Энэ ертөнц дэх дайсагнал, үзэн ядалт хэзээ ч хоргүй үзэн ядалтаар эцэс төгсгөл болохгүй, харин хариу үзэн ядалтгүйгээр арилж алга болно”. Нийгэм дэх дайсагнал гэм нүглийг бүх хүнийг ёс суртахуун, оюун ухааны талаар төгс төгөлдөр, хүнлэг энэрэнгүй үзэлтэй болгох замаар арилгаж болно гэсэн энэрэнгүй сургаал үүсчээ.

Буддизм ял шийтгэлд энэрэнгүй үзлээр хандаж, гэмгүй хүмүүсийг хилсээр шийтгэж огт болохгүй, ер нь шийтгэлийн үүрэг, хэрэглэх хүрээг багасгах нь зүйтэй гэж үздэг.²⁹

Эртний Хятадын улс төр, нийгэм, хууль цаазын сэтгэлгээ нь цаг хугацааны хувьд МЭӨ XIV-XIII зуунаас III-II зууны үеийг хамрах ба агуулгаараа Эртний Хятад орны нийгэм улс төрийн хөгжлийн тусгал, соёлын салшгүй хэсэг. Энэ орны улс төр, нийгэм хууль цаазын сэтгэлгээ нь “Шу-Цзин” хэмээх дурсгал бичигт дэлгэрэнгүй тусгагджээ. “Шу-Цзин”-д хаант төрийн засаглал, түүний зорилго, арга хэрэгсэл, шударга ёс, дэг журам, гэмт хэрэг, түүнд оноох ял шийтгэл зэрэг улс төр, нийгэм хууль цаазын олон асуудал тусгагдсан байдаг. Тухайлбал, ухаалаг, чадварлаг, үр нөлөө бүхий засаг захиргаа нь төр улсыг амар тайван тогтвортой байлгах зорилгоор засаглалын бүх арга хэрэгсэл – сайшаал, шагнал, анхаарал халамж, өршөөл, ял шийтгэл, хүчирхийллийг ухаалгаар зөв хослуулан хэрэглэх замаар харьяат ардуудыг дуулгавартайгаар захирч чадахыг хэлнэ гэжээ.

Энэхүү дурсгалт бичигт нийгмийн дэглэм журам, төрийн хууль цаазыг сахиулах, гэмт хэргийг таслан арилгах арга замын тухай илүү онцгойлж дэлгэрэнгүй өгүүлжээ. Хулгай, дээрэм, аллага, худал хуурмаг явдал үйлдэгчид, урваж итгэл эвдэгсдийг жигшиж шийтгэх ёстой.

Эртний Хятадын нийгэм, улс төрийн сургаалд **Кунзийн** /Кун Фу-цзы-Кун/ /латинаар Конфуций

²⁹ А.Жамбал. Улс төрийн сургаалын түүх /эртний үе/. УБ.,2001. 101-102 дахь тал

хэмээн нэрлэдэг/ оруулсан хувь нэмэр маш их бөгөөд тэр агуу их гүн ухаантан, ёс журам номлогч, сэтгэгч байв. Кунз “Хүн ардыг удирдан захирахын тулд бичмэл хууль гаргах, түүний хэрэгжилт, биелэлтийг айлгаж, сүрдүүлэх, албадаж хүчирхийлэх, шийтгэх замаар хангах гэж оролдох нь үр нөлөө муутайгаар барахгүй олон түмний ёс суртахуун, зан чанарыг зэврээж эвдэнэ. Хэрэв ард олныг хуулиар удирдаж, дэг журмыг ял шийтгэлийн хүчээр тогтоовол ард олон ял шийтгэлээс айж зайлсхийх боловч ичиж зовохыг болино” гэжээ.

Кунз ял шийтгэл, тэр дотор цаазаар авахыг тууштай эсэргүүцэж, гэмт хэрэгтнийг хүмүүжүүлж засах, болохгүй бол дахин хүмүүжүүлэх хэрэгтэй³⁰ гэж сургажээ.

Манай эриний өмнөх V-III зуунд хятад оронд эдийн засаг, нийгэм, улс төрийн томоохон өөрчлөлт, шинэтгэлийн үзэл санааг боловсруулагчдыг Легистүүд буюу хуульчид, тэдний сургаалийг “Легизм” гэж нэрлэх болсон байдаг.

Легизмийг үндэслэгч **Шан Ян** /МЭӨ 390-338 он/ “Зөөлөн сэтгэл, хүнлэг ёс бол буруу үйл хэргийн эх үндэс болно. Кунзийн сурталтангууд шиг сайн үйл, үлгэр жишээнд хичнээн уриалан дуудаад ашиг тус гарахгүй. Тэд бол хоосон ярьж ард түмний хүзүүн дээр сууж буй бусдын хүчээр амьдрагсад мөн. **Жинхэнэ сайн үйл, үлгэр жишээч байдал шийтгэлээс эхтэй байдаг. Бага зэргийн гэм буруутайг ч цаазаар авах хүртэл хатуу шийтгэх хэрэгтэй.** Хүмүүсийн бүхий л үйл ажиллагааг хуулийн заалт, хэм хэмжээгээр хатуу дэглэн зохицуулж, төрийн сүр хүч, хууль журмын шаардлагыг айл гэр бүл, хүн бүрийн яс маханд нь тултал нь мэдрүүлж, айлган түгшүүлэх замаар нийгмийн задрал, эмх журамгүй байдлыг хазаарлан зогсоож болно. хуулийн зорилго, утга учир үүнд оршино”. “Ухаантай мэргэд хуулийг боловсруулан гаргаж, мунхагууд нь тэр хуулиар хазаарлагдаж удирдуулна. Хуулийн онцлог бол түгээмэл, хатуу, хүн бүрт адил тэгш үйлчилдэгт оршино”.

Шан Ян, удирдлагын хэрэгсэл болгож шашны урамшууллыг шийтгэлтэй оновчтой хослон хэрэглэх хэрэгтэй гэж үзсэн байна. “Аймхай хулчгарууд шийтгэлээс айсанд аар эрэлхэг зоригтой болдог, эрэлхэг зоригтонгууд нь шагналд хөтлөгдөж үхэх сэхэхээ үзтэл баатарлагаар тулалдана”³¹ гэж сургажээ.

Эртний Грекчүүдийн ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээний зонхилох хэв маяг, арга нь домгийн үзэл байсан бөгөөд үүгээр нийгэм-улс төр, хууль цаазын утга санааг тайлбарлах болсон.

Энэ үеийн нэг төлөөлөгч болох **Гомер** /МЭӨ VIII зууны үе/ нь “Зевс бурхан бол түгээмэл шударга ёс, ёс суртахуун, эрх зүйг сахиулан хамгаалагч,

тэдгээрийг зөрчигсдийг хатуу шийтгэж цээрлүүлэгч дээд хүч мөн” гэж ойлгожээ. Тэрээр шударга ёсыг зөрчих явдал нь зөвхөн хүн, хүний нийгмийн эсрэг үйлдэл төдийгүй мөн бурхны эсрэг тэрсэлсэн үйлдэл байдаг тул бурхан тийм гэм нүгэлтнийг хатуу залхаан цээрлүүлнэ гэж үзсэн байна.

Эртний Грекийн “Долоон цэцэн”-ий нэг **Периандр** язгууртны ардчиллыг талархаж, “Гэмт хэрэгтнийг яллаж шийтгэснээр санаа бүү амар. Түүний оронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэгчүн”.

Солан /МЭӨ 638-539/ “Хууль, хуулийн засаглал гэдэг бол эрх зүй ба хууль ёсны төрийн албадлагын нэгдэл мөн. Төрийн амьдралд хууль ёс шийдвэрлэх үүрэгтэй байх ба тухайн төр шударга хууль ёсгүй бол тэнд хамгийн муу муухай нүгэл үйлдэгддэг, харин шударга хуулийг эрхэмлэсэн төр хүчтэй байдаг” гэсэн байдаг.³²

Пифагор /МЭӨ 580-500/ “Шударга хууль ноёрхож буй төр улс хамгийн үлгэр жишээч, шилдэг нь юм. Тийм хуулийг хүндэтгэж биелүүлэх нь эрхэм чухал сайн үйл бөгөөд сайн хууль нь өөрөө эрхэм үнэт зүйл мөн болно. Харин адгийн муу зүйл бол засаг захиргаагүй, эмх журамгүй явдал болно” гэж үзсэн.³³

Демокрит /МЭӨ 470-365/ “... Шударга ёсыг зөрчиж, түүнд саад болж, хор хүргэвэл нийтийн сайн сайхны төлөө хатуу чанга шийтгэл хүлээх ёстой” гэж байв.

Софистуудын бие төлөөлөгч **Фрасимах** /МЭӨ V зууны хоёрдугаар хагас/ “Төр барьж буй этгээд хуулийг өөрийн ашиг сонирхолд тохируулж баталдаг. Тухайлбал, ардчилсан засаг ардчилсан хуулийг, дарангуй засаг дарангуйлсан шинж бүхий хууль гаргана. Тэдгээрийн аль аль нь гаргасан хуулиа шударга сайн хууль хэмээн үзнэ”.

Тэр түүхэнд **хүчирхийллийн гүйцэтгэх үүргийг бодитойгоор гарган тавьж** засаглал ба хууль нь төрийн хүчирхийлэлд тулгуурлана, хэн нь хүчтэй, хэн нь засгийн эрхийг барьж байна уу, түүний үзэл бодол, үнэлэмж ёс суртахуун ноёрхоно³⁴ гэж сургасан нь нийгмийн хөгжлийн бодит байдалд тохирсоор иржээ.

Сократ /МЭӨ 469-399 он/ Эртний грекийн төдийгүй нийт хүн төрөлхтний оюун сэтгэлгээний түүхэн дэх гарамгай сэтгэгч, ёс суртахуун номлогч Сократ “... хууль ёсны зүйл нь шударга, шударга зүйл нь хууль ёсны байдаг... Иргэд, төрийн байгууллага, албан тушаалтнуудын зүгээс шударга бус, алдаа буруутай шийдвэр, заалт, заавар гаргавал тэдгээрт хуулийн хүрээнд, хүч хэрэглэхгүйгээр /ял шийтгэхгүйгээр/ зүй зохистойгоор эсэргүүцэж засаж залруулахыг оролдох хэрэгтэй”³⁵ гэж сургасан.

Платон /МЭӨ 427-347/ сүүлчийн томоохон

³⁰ Конфуций. Уроки мудрости. Сочнения. Харьков.1998. 16-19 дэх тал

³¹ История политических и правовых учении. М.,1997. 38-41 дэх тал

³² Эрх зүйн философи. УБ.,1998. 61 дэх тал

³³ Мөн тэнд. 62 дахь тал

³⁴ Материалисты Древней Греции. М.,1955, 168 дахь тал

³⁵ Ксенофонт. Воспоминания о Сократе. М.,1952. 12 дахь тал

бүтээл болох “Хуулиуд” зохиолдоо “Хуулийн нарийн чанд биелэлтийг шударга шүүх хангах ёстой. Хэрэв хууль хүчин чадалтай биш, хэн нэгний эрхшээл нөлөөнд байвал, түүнчлэн шүүх, шүүгчид ёс журмаараа ажиллаж чадахгүй /ялыг шударга хэрэглэх чадваргүй/ юм бол төр нь төр биш болж мөхөл нь ойртоно. Харин хууль нь төр баригчдын захирагч эзэн нь байж чадах юм бол төр ба төрд хэрэгцээтэй эд баялаг бүрэн бүтэн байх болно”³⁶.

Грекийн агуу их сэтгэгч **Аристотель** “Шударга ёсны ойлголтыг төрийн тухай үзэл төсөөлөлтэй холбож үзээд ... шударга ёсны хэмжүүр болж буй эрх зүй нь улс төрийн харилцааг зохицуулагч хэм хэмжээ болдог. Тэр хууль, хэв журам зөрчих, гэмт хэрэг үйлдэх явдал, тэр дотроо хамгийн жижиг сажиг зөрчлийг ч гаргуулахгүй байх, албан тушаалтнуудад хялбар олз олох, хөрөнгө завших бололцоо олгохгүй байх нь төрийн үүрэг гэж үзсэн байна”³⁷.

Эллинизмийн үеийн гол төлөөлөгч **Эпикур** /МЭӨ 311-270/ “Хууль ёс нь жам ёсны шинжтэй биш ч гэсэн хүмүүсийн хамтын амьдрал аюулгүй тайван байдалд хэрэгтэй... Төр улсын дотор хувь хүмүүс өөр өөрийн хувийн амьдрал, зол жаргалаа хичээж аж төрдөг учраас тэдний хоорондын харилцаа үйл ажиллагааг зохицуулах хууль цааз зайлшгүй шаардлагатай болно. Ухаантай мэргэд ухаан санаа, нинжин сэтгэлээрээ албадлагагүйгээр ёс журамтай амьдарч чадна. **Харин мөнгө, нэр хүнд, эрх мэдэл, жаргал цэнгэлд тэмүүлж, хүсэл шуналд нь хэмжээ хязгаар гэж байдаггүй мунхагуудыг хууль, албадлага, ял шийтгэлээр л тогтоон барьж, дэг журамтай байлгахгаас өөр аргагүй. Тэд ял шийтгэлээс айна. Хууль нь ухаантай, төгс төгөлдөр ёс суртахуунтай хүмүүсийг харц олноос хамгаалах, хувь хүмүүсийн эрх чөлөө, бие даасан тусгаар байдлыг хангах албан ёсны баталгаат хэрэгсэл болно**” гэж сургаад Эпикур, өөрөө хуулийг дээдэлж, гэмт хэрэг, ялангуяа хүний эсрэг гэмт хэрэг үйлдэхгүй байх, өөртөө хяналт тавьж хариуцлагатай байхыг захиж уриалж байв.³⁸

Стойкуудын зарим төлөөлөгчид “Гэмт хэрэг бол нүгэл бөгөөд түүнд ялгавартай тодорхой хандах хэрэгтэй. Гэхдээ гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг заавал шүүж ял оноох хэрэгтэй” гэсэн нэгдмэл байр суурийг стойкууд тууштай баримталж байв. Эртний Ромын уран илтгэгч **Марк Туллий Цицерон** /МЭӨ 106-43/ “Төрийн тухай”, “Хуулийн тухай”, “Үүрэг, зорилтуудын тухай” зэрэг зохиол бүтээл туурвисан. Тэр “Хуулиуд” зохиолдоо “Эрх зүйн үндэс нь байгалийн шударга ёс юм. Шударга ёс бол байгалийн ба хүний ертөнцийн мөнхийн өөрчлөгдөшгүй, салшгүй шинж чанар юм. Шударга ёс гэдэг бол хүнд муу зүйл хийхгүй байх, бусдын эрхэнд халдахгүй байх явдал юм. Хуулийн үйлчлэлийн дор бүгд захирагдах учиртай.

Хүмүүс үүргээ биелүүлэх, буянтай, сайн үйлтэй байх, нүгэл, гэмт хэрэг үйлдэхгүй байхыг жам ёсны эрх, жинхэнэ хууль хатуу шаардана. **Тэдгээрийн зөрчиж тэрсэлдэж байгаа хүн бүр төрийн хуулиар шийтгэгдэхгүй үлдэж ял завшсан ч гэсэн бурхан түүнийг зайлшгүй гэсгээж цээрлүүлнэ**”³⁹ гэж Цицерон сургажээ.

Дундад зууны үеийн гүн ухааны төлөөлөгч болох **Аквины Фома** “Төрийн удирдлагын тухай” зохиолдоо “Хууль бол хүмүүсийн зорилгодоо хүрэх дүрэм, журам юм гээд хуулиудыг:

- а/ Мөнхийн хууль
- б/ Жам ёсны хууль
- в/ Иргэний хууль

г/ Бурханы хууль гэж ангилан авч үзээд Хүмүүс угаасаа хорлонтой үйл хэргийг /гэмт хэрэг/ хийх хүсэлтэй байдаг учир тэднийг энэхүү хор холбогдлоос ангижруулахын тулд хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх /ял хэрэглэх/ замаар дэг журамтай байлгаж, буянт сайн үйлийг хийлгэх ёстой. Энэ үүргийг хүний хууль гүйцэтгэж чадна”⁴⁰ гэж сургасан.

Пидданы Марсилийн /1275-1343/ үзлээр хууль нь бурхны ба хүний гэсэн хоёр хэлбэртэй. Бурхны хууль нь хүний үйлдсэн нүгэл, буяныг ялгаж, нүглийг гэсгээн цээрлүүлж, буянт үйлсийг өргөмжлөн урамшуулах зорилготой байдаг бол хүний хууль нь үнэн худал хоёрыг ялгаж, төрийн засаглалыг бат бэх байлгаж, шударга ёсыг тогтоох зорилготой. Энэ зорилтыг хүч хэрэглэх албадах аргаар хэрэгжүүлэх ёстой. Харин сүм хийд хүнийг шийтгэх эрхгүй. Ял шийтгэлийг зөвхөн төр л оногдуулах ёстой гэсэн үзэл санааг баримталж байв.

Шинэ үеийн эрх зүйн болон гүн ухааны сэтгэгчид албадлага, цээрлэлийн болон гэмт хэрэг, ялын тухай өөрсдийн зохиол бүтээлдээ олонтаа хөндсөн байдаг. Английн материалист гүн ухаантан **Томас Гоббс** /1588-1679/ “... Нийтлэг эрх ашгийг хамгаалах үүднээс шаардлагатай бүх хүч хэрэгслийг ашиглах эрх бүхий этгээд төр засаг бүрэлдэн бий болох ба энэхүү төрийн засаглагч хууль тогтоох, хууль зөрчигчдийг цээрлүүлэн шийтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх” тухай хөндсөн байдаг.⁴¹

Жон Локк /1632-1704/ “Хууль нь эрх чөлөөг үгүйсгэх бус харин ч түүнийг хамгаалах, өргөтгөх зорилготой бөгөөд хаана хууль ёс үгүй байна тэнд эрх чөлөө үгүй, хууль зөрчигчдийг хатуу цээрлүүлэх ёстой” гэсэн алдарт үгээ айлдсан.

Францын соён гэгээрүүлэгч, алдарт хуульч **Шарль Луйе дэ Секондат Монтескье** /1689-1755/ “Хуулийн амин сүнс” бүтээлд “**Засаглалын төрөл бүрийн хэв маягаас үүдсэн зарчим нь иргэний хийгээд эрүүгийн хуулийн энгүүн шинж байдалд, хэрэг**

³⁶ Платон. Хуулиуд. М.,1957. 957 дахь тал

³⁷ Аристотель. Дээд ёс суртахуун. УБ.,2008. 60 дахь тал

³⁸ Материалисты Древней Греций. М.,1960, 222 дахь тал

³⁹ История политических и правовых учений. Древний мир. М.,1985. 285 дахь тал

⁴⁰ Д.Лүндээжанцан, Н.Жалбажав, Д.Отгонтуяа. Эрх зүйн философи. УБ.,1998. 104 дэх тал

⁴¹ Т.Гоббс. Левиафан. М.,1951. 117 дахь тал

шүүх хэлбэрт болон ял онооход хэрхэн нөлөөлөх вэ” хэмээх зургаадугаар дэвтэрт ял шийтгэл түүнийг хэрэглэх тухай дэлгэрэнгүй авч үзсэн байдаг.

Ш.Л.Монтескье, Ромд шийтгүүлэгчийн илэрхий гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон бол шүүн тасалдаг байжээ. Оногдох ялыг хуулиар тогтоох бөгөөд уг хэрэг нотлогдсон бол шүүгч хуулийн заалтаар ялладаг. Үүний тулд түүнд нүд л хэрэгтэй. Шүүгч эрүүгийн хэрэг шүүхдээ:

а/ Шийтгэл үзүүлж байна

б/ Цагаатгаж байна

в/ Эргэлзэж байна гэсэн гурван томьёоллоор шийдвэрээ илэрхийлдэг.

Хатуу ял шийтгэл эзэрхий засаглалтай улсад л илүү тохиромжтой, ийм засаглалын зарчим нь айдас л байдаг. Ш.Л.Монтескье зайлшгүй шаардлагаас үүдээгүй аливаа шийтгэл нь харгислал юм гэж оновчтой тэмдэглэжээ. **“Хаант болон төлөв даруу засаглалтай улс оронд сайн хууль зохиогч гэмт хэрэгтнийг шийтгэхээсээ илүү гэмт хэргийг гарахаас өмнө урьдчилан сэргийлдэг, залхаан цээрлүүлэхээсээ илүү ёс суртахууныг нь ариусгадаг”**⁴² гэж алдарт сургаалаа айлдсан.

Төв даруу засаглалд бол өр зөөлөн сэтгэл ноёрхож байдаг ч сайн хууль зохиогч /Мэргэн хуульч. С.Ж/ гэмт хэрэгтэн бүрийг яллаж чаддаг. Туршлагаас үзвэл ял шийтгэл хөнгөвтөр улс оронд ийм шийтгэл нь иргэний ухаан бодолд бусад оронд мөрддөг их хатуу шийтгэлээс ялимгүй бус айхавтар сэтгэгдэл төрүүлдэг ажаам. Манай үед цэргээс оргох нь байнгын болжээ. Оргогчдыг цаазаар авах ял тогтоосон. Гэвч оргогчдын тоо цөөрөөгүй. Иймд шийтгэлийг чангатгах нь эсрэг үр дагаварт хүргэх аюултай. Хүнийг туйлын хатуу аргаар залхаах хэрэггүй. Бидэнд байгалиас өгсөн удирдах аргыг хямгатай хэрэглүүштэй.

Эх захаа алдсан аливаа явдлын цаад шалтгааныг нарийвчлан тогтоох бол тэр нь шийтгэлийн сул талаас биш, гэмт хэрэгт цээрлэл үзүүлээгүйгээс гарч байгаа юм гэдгийг ухаарах болно гэж хатуу харгис ял шийтгэл ямагт оновчгүй байдаг талаар бичжээ.

Ш.Л.Монтескье, ял шийтгэл ба гэмт хэрэг хоёрын зохицолдооны талаар тусгайлан авч үзжээ. Тэр “Аливаа ял шийтгэл ба гэмт хэрэг хоёр зохицсон, өөрөөр хэлбэл, оноож буй шийтгэл хэргийн хүнд, хөнгөнд яв цав тохирсон байх ёстой. Манайд их замд дээрэм хийсэн хүн, аллага үйлдэж дээрэм хийсэн хүн хоёрт адил шийтгэл оноодог тэнэг явдал байгаа юм. Нийтийн аюулгүй байдлын үүднээс иймэрхүү гэмт хэрэгт ялгаварта ял оноогуштай нь мэдээж биздээ. Хятадад аймшигт дээрэмчний биеийг тасчин хаядаг, жирийн хулгайчийг бол үгүй. Ийм ялгаатай тул хулгайч бээр хүн хороодоггүй. Москва хотод хулгайч, алуурчин хоёрын шийтгэл яг адилхан. Тэгэхээр дээрэм тонуул болоход хүн заавал алагддаг. Хэрэв ял шийтгэлд ялгаа үгүй бол өршөөл

⁴² Шарль Монтескье. Хуулийн амин сүнс. УБ.,2009. 72-73 дахь тал

хүртэх найдвар төрүүлэх ялгавар хийж өгөх ёстой юм даа”⁴³ гэж ял шийтгэлийн зохицолдооны асуудлыг Хятад, Япон, Орос зэрэг улсуудын бодит жишээгээр тайлбарлажээ.

Германы сонгодог философийг үндэслэгч, нэрт сэтгэгч, эрх зүйн философийн үзэлдээ үүсмэл эрх болон эрүүгийн эрх зүйн тухай тусгайлан авч үзсэн. **И.Кантынхаар** “Гэмт хэрэг гэдэг бол нийтлэг эрх ашгийг зөрчсөн үйлдэл бөгөөд зөвхөн нэг субъектын эрх чөлөөнд халдсан гэмт хэрэг төдийгүй нийт субъектын эрх чөлөөнд халдсан гэмт халдлага юм. Иймд гэмт хэрэгт ял шийтгэл зайлшгүй. Ял гэдэг угтаа нөхөн төлөх эрх юм. Өөрөөр хэлбэл, энэ нь засан хүмүүжүүлэх хэрэгсэл биш хэмээн үзсэнээрээ ялын ашигтай шинжийг үгүйсгэсэн байна. Ял шийтгэл нь нөхөн төлөх эрх болохынхоо хувьд үйлдэгдсэн гэмт хэрэгтэйгээ адил агуулгатай байх ёстой гээд үүнийгээ тэрээр, бусдын амийг санаатайгаар хороосон тохиолдолд ял шийтгэл нь мөн л цаазаар авах ял байх ёстой хэмээн тайлбарласан.

Хэрэв гэмт хэрэгтэн эд хөрөнгө, мөнгөний төлөө хүний аминд халдаж амь насыг нь бүрэлгэсэн бол уг этгээд хохирогчийн амийг мөнгө, эд хөрөнгөнөөс дор үзсэн байх тул гэмт хэрэгтний амийг ч мөн тэгж үзэх ёстой. Гэхдээ хүний амь хохироосон зарим нөхцөлд цаазаар авах ял хэрэглэхгүй байж болно. Тухайлбал, олон нийтийг хамарсан үймээн самуун, бослого хөдөлгөөн гарсны улмаас хүний амь нас хохирсон нөхцөлд, учир нь босогчдыг бүгдийг цаазлах боломжгүй, халз тулаан /дуэль/-ы улмаас хүний амь хохироосон бол, учир нь сайн дурын үндсэн дээр харилцан бие биенийхээ амийг хохироож байгаа тул эдгээр тохиолдлуудад цаазаар авах ялыг хэрэглэхгүй байж болно. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулж байгаа нь мөн чанартаа шударга ёсыг хэрэгжүүлж байгаа хэрэг учраас ял нь зөвхөн эрх зүйн төдийгүй ёс суртахууны шинжийг агуулдаг”⁴⁴ хэмээн үзэж байв.

Гэмт хэрэг ба ялын тухай И.Кантын сургаалыг үргэлжлүүлж хөгжүүлсэн **Георг Вильгельм Фридрих Гегелийнхээр** /1770-1831/, гэмт хэрэг гэдэг бол эрх зүйг санаатай зөрчих явдал юм. Гэмт хэрэг гэдэг бол хамгийн энгийнээр авч үзвэл хохирогчийн эсрэг халдсан хүчирхийлэл юм. Гэмт хэрэгтнийг шийтгэх явдал нь ёс суртахууныг бий болгож байгаа зүйл юм. Иймд ялын зорилго нь Гегелийн үзлээр, хохирогчийн үгүйсгэгдсэн эрхийг сэргээх явдал бөгөөд үүгээрээ ял нь эргээд гэмт хэргийг үгүйсгэдэг байна. Ийнхүү Гегель Платоны нэгэн адил ялыг шийтгэл гэхээсээ илүү “гэмт этгээдийн эдлэх эрх” гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, “Гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдэж байгаа нь гэмт этгээд өөрөө өөртөө ял хэрэглэх зөвшөөрлийг олгож байгаа юм”⁴⁵. Энэ мэтчилэн Гегелийн үзсэнээр

⁴³ Шарль Монтескье. Хуулийн амин сүнс. УБ.,2009. 80 дахь тал

⁴⁴ И.Кант. Зохиолуудын 4-р боть. 299-301 дэх тал

⁴⁵ Г.Гегель. Философия права. М.,1990. 80 дахь тал

гэмт хэрэг, ял хоёр гадаад талаараа ялгаатай боловч дотоод талаараа нэгдмэл ойлголт юм. Учир нь ял нь гэмт хэргийн үр дагавар, түүнийг нэг тал юм. Ялын зорилго нь айлган сүрдүүлэх буюу засан хүмүүжүүлэх зорилготой байвал ямар ч үр дүнд хүрэхгүй. Харин ялын жинхэнэ зорилго бол шударга ёсыг тогтоох / зөрчигдсөн эрхийг сэргээх/ явдал юм⁴⁶ хэмээн үзэж байв.

Чезаре Бекариа /1738-1794/ нь эрүүгийн эрх зүйн онолыг үндэслэгчдийн нэг бөгөөд “Гэмт хэрэг ба ял” хэмээх бүтээл туурвин олны хүртээл болгосон. Орчин үеийн гэмт хэрэг, ялын сургаалд чухал хувь нэмэр оруулсан гүн ухаантан, сэтгэгч хуульч юм. Тэр, гэмт хэрэг, ялын тухай цогц сургаал боловсруулсан суу билэгтэн юм. Ч.Бекариа “Хуулийг үл хэрэгсэж хүй нэгдлийн эмх замбараагүй байдалдаа эргэж очих гэсэн хүмүүсийн дур зоргоороо байх хүсэл эрмэлзлийг хазаарлах мэдрэхүйг цочроогч бол хууль зөрчигчдөд хүлээлгэдэг ял болой. Цэцэн мэргэн үг, эсхүл уран гоё ухуулга, тэр бүү хэл, хөдөлбөргүй үнэн гээч нь хүртэл ахуй орчны нөлөөгөөр төрсөн хүсэл шуналыг тогтоон барьж чадахгүй учраас цочроогч болох ял үүссэн. Эрх баригчаас гэмт хэрэгтэнд ял оногдуулах эрх юунд үндэслэгдсэн байж таарах вэ гэвэл тэр нь нийтийн ашиг тусыг хувь этгээдүүдийн халдлагаас хамгаалах шаардлага болой. Тэгээд аюулгүй байдал нь хэдий ариун гэгээн, халдашгүй дархан байхын хэрээр эрх баригч харьяат ардаа төдий хэмжээгээр ял шийтгэл шударга байна гэсэн үг.

Гэмт хэрэгт оногдуулах ялыг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд шударга ёсны зарчмын дагуу ямар ч шүүх өөрөө нийгмийн нэг хэсэг атлаа нийгмийн гишүүдэд зориулан ял тогтоож болохгүй. Хуульд зааснаас хатуу болон хуулиар тогтоогоогүй ял оногдуулсан нь шударга байвч түүнийг ял гэж лав болохгүй. Ийм учраас шүүх нийгмийн ашиг тусын төлөө ямар ч нөхцөл, тайлбартайгаар гэмт хэрэгт хуулиар оногдуулсан ялаас илүү ял оногдуулж болохгүй. Ял харгис хатуу байгаа нь нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөхгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд саад хийхгүй байвч ердөө л ямар ч ашиг тусгүй байх нь бий.

Нийтийн ашиг сонирхол гэмт хэрэг үйлдэгдэхгүй байхыг тэр дундаа нийгэмд илүү аюултай гэмт хэрэг гарахгүй байхыг шаардана. Хүний үйлдлийн хязгааргүй олон элдэв янз хэлбэрт геометрийг ашиглаж болдогсон бол гэмт хэргийг хүндээс нь хөнгөн рүү нь ангилсан ийм ангилал байж болох. Гэхдээ ухаалаг хууль тогтоогчийн хувьд хүнд ноцтой гэмт хэрэгт хөнгөн ял шийтгэл оногдуулж орхихгүйн тулд тогтоосон шатлалынхаа хэд хэдэн гол цэгийг тодорхойлоход л хангалттай.

Хэрэв таашаал буюу зовиур шаналгаа нь мэдрэх чадвартай амьд амьтныг хөдөлгөгч хүч бөгөөд хууль тогтоогч шагнал, шийтгэлийг хүмүүсийн хөдөлгөгч

хөшүүрэг болгон ашигласан гэж үзвэл гэмт хэрэг нь өөртөө ялыг бий болгоно гэнээс үүдэж тэдгээрийг хооронд нь тохируулж чадаагүйгээс үл анзаарагдах боловч өргөн тархсан зөрчилдөөн үүсч байдаг нь илт болно. Хэрэв нийгэмд аюулгүй хор уршиг учруулж буй хоёр өөр гэмт хэрэгт адилхан ял оногдуулбал, хэн нэгэн өөрт нь илүү ашиг өгөх ноцтой гэмт хэргийг үйлдэхэд юугаар ч саад хийж чадахгүйд хүрнэ”⁴⁷ гэж “Гэмт хэрэг ба ял” бүтээлдээ бичсэн нь одоо ч ач холбогдлоо алдаагүй байна.

Францын нэрт эдийн засагч **Фредерик Бастиа** /1801-1850/ “Хууль” хэмээх алдарт бүтээлдээ “Хууль завхарч дуусчээ... Хууль бүхий л төрлийн ховдог шунахайчуудын зэвсэг болжээ. Хууль нь өөрийнхөө шууд үүрэг болох гэмт хэргийг хянан, бузар бусгай бүхнийг шийтгэхийн оронд түүнийг төрүүлж байгаагаараа өөрөө буруутан. Хэрэв энэ бүхэн үнэн бол чухамхүү ноцтой баримт болох бөгөөд үүнд анхаарлаа хандуулахыг иргэдээс шаардах нь миний ёс суртахууны үүрэг билээ”⁴⁸ гэж онцлон дурдсан нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд сургамж болох юм.

Төр эрх зүйн тухай Марксист онолд К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин нар гэмт хэрэг, ялын тухай асуудалд анхаарлаа зориуд хандуулсан байдаг.

К.Маркс “Эрх зүй нь ноёрхогч ангийн амьдралын материаллаг нөхцлөөр утга агуулга нь тодорхойлогддог, тэрхүү ангийн хууль болон өргөмжлөгдсөн хүсэл зориг”⁴⁹ гэж “Коммунист намын тунхаг” бүтээлдээ эрх зүйн алдарт тодорхойлолтоо оруулсан. Тэр “Нийгмийн харилцааны ямар ч хүрээнд хууль тогтоогч хуулийг хийдэггүй, бүтээдэггүй, зөвхөн түүнийг томъёолдог. Учир нь Эрүүгийн хуульд байгаа ял нь эцсийн эцэст эдийн засгийн болон нийгмийн бусад хүчин зүйлүүдээр л нөхцөлдсөн байдаг”⁵⁰.

Эдийн засгийн урагшлах хөдөлгөөн нь өөрийнхөө бий болгосон харьцангуй бие даасан шинжтэй улс төрийн хөдөлгөөний эргэх нөлөөллийг өөртөө амсч байдаг.⁵¹ К.Маркс, Ф.Энгельс нар “Хуульчлагдсан ял нь ямар ч тохиолдолд шударга, гэмт хэрэг үйлдсэн хүн бүрт тэгш үйлчлэх ёстой”⁵² гэжээ.

Аливаа төр гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн, улмаар шоронд ял эдэлж буй иргэдийнхээ хувь заяанд хайхрамжгүй хандаж болохгүйг “Төр бодлогогүйгээр нийгмийнхээ нэг гишүүнийг үүргээс нь чөлөөлж хөсөр хаяж хэрхэвч облохгүй. Тэгснээрээ төр өөрийнхөө амьдралын чухал эрхтэнгээ хүнийсгэж, улмаар иргэдээсээ гэмт хэрэгтэн төрүүлж байна” гэсэн К.Марксын сургаалаас харж болно. Эрүүгийн эрх зүйн онол, хууль тогтоомж шүүхийн практикт К.Марксын “Ямар нэгэн ялгаваргүй ялын цээрлэл нь үр ашиггүй бөгөөд ялыг эрх зүйн үр дагавар болохын

⁴⁷ Чезари Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. Орчуулсан Г.Эрдэнэбат. УБ.,2009, 25-37 дахь тал

⁴⁸ Фредерик Бастиа. Хууль. УБ.,2007. 1-4 дэх тал

⁴⁹ К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. I боть. 126 дахь тал

⁵⁰ К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. I боть. 162 дахь тал

⁵¹ Зохиолуудын 37-р боть. 417 дахь тал /орос хэл дээр/

⁵² Зохиолуудын 19-р боть. 33 дахь тал /орос хэл дээр/

⁴⁶ Д.Лүндээжанцан, Н.Жалбажав, Д.Отгонтуяа. Эрх зүйн философи. УБ.,1998. 151 дэх тал

хувьд үнэн хэрэг дээрээ үгүйсгэж /устгаж. С.Ж/ байгаа хэрэг.⁵³

“Ял нь нэгд, гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой хэрэгсэл, хоёрт, гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг хүмүүжүүлэх хэрэгсэл учраас ямар ч тохиолдолд нийгэмд ашигтай байх ёстой.⁵⁴ Мэргэн хуульч нэгэнт үйлдэгдсэн гэмт хэрэгт ял оногдуулахгүй байхын тулд түүнийг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авбал зохино.⁵⁵ Ял нь нийгмийн хэвийн оршин тогтнохын эсрэг үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлөөс түүнийг хамгаалах хэрэгсэл болохоос өөр юу ч биш.⁵⁶” гэсэн ялын талаарх үзэл сургаалууд одоо ч ач холбогдолтой хэвээр байна. К.Маркс “Фейербахын тухай өгүүлүүд” зохиолдоо ялын хүмүүжүүлэх зорилгод хамааруулан “хүмүүс ямагт тэдний амьдралын нөхцөл байдал болон хүмүүжүүлсэн орчны бүтээгдэхүүн болохоор тэд хүмүүжиж зан авирын хувьд өөрчлөгдөж байгаа нь өөрчлөгдсөн нөхцөл байдал болон өөрчлөгдсөн хүмүүжлийн ажлын үр дагавар юм. Хүмүүс ухамсартайгаар нөхцөл байдлыг өөрчилдөг. Ялтныг хүмүүжүүлэгч маань өөрөө хүмүүжсэн байх учиртай”⁵⁷ гэжээ.

Шүүх ял оногдуулахдаа шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдэхдээ удирдлага болгосон сэдэлтийг тогтоох шаардлагатай. Энэ талаар **Ф.Энгельс** “Хүний нийгмийн шүүхэд оюун ухаант хүн бүр ямарваа нэг үйлдлийг тодорхой зорилгодоо хүрэхийн тулд хийдэг. Ямар ч хүн тодорхой зорилгогүй үйл ажиллагаа явуулахгүйн адил гэмт хэрэг бүр тодорхой зорилгоор үйлдэгдсэн байдаг”⁵⁸ гэжээ.

В.И.Ленин хуульч болохын хувьд ялын талаар олон сургаал айлдсан байдаг. Тухайлбал, тэр зөвлөлт засаг тогтох үед тэр үеийн төрийн эрүүгийн бодлогын хөгжлийг төсөөлөхдөө “ялыг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах нь чухал боловч аажмаар шоронг хүмүүжлийн байгууллагаар солих, хорих ял хэрэглэхийг эрс багасгаж, тэнсэн харгалзах арга хэмжээг өргөн хэрэглэх цаг мөд ирнэ”⁵⁹.

Бид юу ч боллоо гэсэн эхлээд итгүүлж, дараа нь албадах ёстой гээд итгүүлэх аргын давуу талыг тодорхойлохын хамт шинэ нийгэм байгуулахад албадлагыг хэрэглэх нь зүйн хэрэг. Итгүүлэх, албадах аргуудын харьцаа, хоорондын хамаарал нь нийгмийн хөгжлийн объектив нөхцөлүүдээр тодорхойлогдох учиртай. Эдгээр нөхцөлүүдийн өөрчлөлт нь итгүүлэлт, албадлага хоёрын харьцааны шинж, тэдгээрийг хэрэглэх арга хэрэгсэл болох ялд шууд нөлөөлж байдаг.⁶⁰

⁵³ К.Маркс, Ф.Энгельс. Зохиолуудын 1-р боть. 132 дахь тал /орос хэл дээр/

⁵⁴ Зохиолуудын 1-р боть. 123 дахь тал /орос хэл дээр/

⁵⁵ Зохиолуудын 1-р боть. 131 дэх тал /орос хэл дээр/

⁵⁶ Зохиолуудын 8-р боть. 531 дэх тал /орос хэл дээр/

⁵⁷ Зохиолуудын 3-р боть. 14 дэх тал /орос хэл дээр/

⁵⁸ К.Маркс, Ф.Энгельс. Зохиолуудын 21-р боть. 306 дахь тал

⁵⁹ В.И.Ленин. Зохиолуудын 36-р боть. 194 дэх тал

⁶⁰ Зохиолуудын 36-р боть. 178 дахь тал. /орос хэл дээр/

Эрүүгийн хууль бол гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг ерөнхий байдлаар хуульчилдаг учраас гэмт хэргийн бүрэлдэхүүний хийсвэр томъёоллыг өөртөө агуулж байдаг. Хууль бол ерөнхий, харин гэмт үйлдэл, эс үйлдэхүй, түүнийг үйлдсэн хүн нь тодорхой байдаг. Тийм учраас шүүх хуульд заасан ялыг өөрийнхөө үзэмж, дотоод итгэл, эрх зүйн ухамсарт тулгуурлан ялгавартайгаар хүн бүрт тохируулан хэрэглэх ёстой.⁶¹

Шүүх хэрэгтэнд ял оногдуулж, улмаар цээрлүүлэх, хүмүүжүүлэх нөлөө үзүүлдэг учир ял нь гэмт хэрэгтэй тэмцэх чухал хэрэгсэл юм.⁶² гэж тус тус сургажээ.

В.И.Ленин, ялыг ялгавартайгаар хэрэглэх талаар “Ялыг ялгавартай оногдуулах нь **нэгд**, Оросын газар нутгийг адгийн муу хортой мэрэгчид болох дээрэмчид, сорон мөлжигч бясаа адил хөрөнгөтөн баячуудаас цэвэрлэх зорилгыг хангах ёстой. Тэгэхийн тулд **хоёрт**, хэдэн арван баячууд, мөн дээрэмчид, хулгайчид, ажлаас хойш суугч ажилтнуудыг нэг дор шоронд суулгавал таарна. **Гуравт**, тэднийг шоронгоос суллагдмагц хүн бүрт засрах хүртэл нь шар картаар хангаж, зан байдал, үйл хөдөлгөөнийг хатуу хяналтанд байлгах. **Дөрөвт**, нийгэмд тустай хөдөлмөрөөс хойш суугч, гэм буруутай этгээдүүдийг газар дээр нь буудвал таарна. **Тавд**, гэмт хэрэг үйлдсэн хүмүүст ялгавартай хандаж ялыг нь тэнсэн харгалзах, эсхүл ах дүү, төрөл төрөгсөд, хамт олны даалтанд өгч байх нь хүнлэг зарчимд нийцнэ”⁶³.

Зөвлөлт холбоот улсад /ОХУ/ ялын тогтолцоог боловсронгуй болгох үйл ажиллагаа В.И.Лениний тухайн үед боловсруулсан төрийн эрүүгийн бодлого, эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэл, ял хэрэглэж ирсэн практикийг харгалзаж байв. В.И.Ленин:

1. Тэнсэх
2. Олон нийтийн өмнө буруушаах
3. Хорих ялыг гэр орондоо амьдрах эрхтэй албадлагын хөдөлмөрөөр солих
4. Шоронг аажимдаа хүмүүжлийн байгууллагаар солих
5. Гэмт хэрэгт холбогдсон цэргийн албан хаагчид, ажилчдын хувьд нөхдийн шүүхээр хэлэлцэж шийтгэх ялын төрлийг тодорхойлж байв.⁶⁴

Монголын гүн ухаан бурхан шашны номлолд гэмт хэрэг, ялангуяа хүчирхийлэл, албадлагын илэрхийлэл болох ялын талаар олонтаа дурдсан байдаг.

Буддын гүн ухааны тогтсон таалал нь дорно дахины сэтгэлгээний түүхэнд энэтхэгчүүд, хятад, япон, төвдүүдээс гадна Монголчуудын гүн ухааны уламжлал энэхүү мэдлэг ухааны бүрэлдэхүүн хэсэг болон хөгжиж иржээ. Эдгээр гүн ухаан, шашны номлол сургаал нь “Ганжуур”, “Данжуур” болон Бурхан багшийн сургаалд тусгагджээ.

⁶¹ Зохиолуудын 4-р боть. 366 дахь тал /орос хэл дээр/

⁶² Зохиолуудын 36-р боть. 549 дэх тал /орос хэл дээр/

⁶³ Зохиолуудын 35-р боть. 204 дэх тал /орос хэл дээр/

⁶⁴ Зохиолуудын 38-р боть. 408 дахь тал /орос хэл дээр/

Бурхан багшийн сургаалд "... Хаан нь ард түмнийхээ зовлон жаргалыг мэддэг, гэмт хэрэг болон гавъяа, шийтгэлийн тухай мэдээллийг сайтар авдаг байх, ер нь бүх юмыг мэдэх ёстой. Тэрбээр гэмт хэрэгтнийг үйлдсэн хэргийнх нь хүнд, хөнгөнөөс шалтгаалан шийтгэн цээрлүүлж, гавъяа зүтгэлээр шалгарагсдыг шагнаж урамшуулах ёстой. Хаадын хаан нь Үнэний хаан гэж өргөмжлөөд үнэний хаан амь үл хороож, хулгай үл хийж, буруу үл хурьцаж, үл хуурч, муу үг үл хэлж, хоёр нүүр үл гаргаж, дэмий үл чалчиж, ховдог шунахай сэтгэлийг үл мэдэж, үл уурлаж уцаарлана. Хаан хүн эдгээр арван сайн үйлээрээ ард түмнийхээ арван хар нүглийг арилгадаг"⁶⁵ хэмээн Бурхан багш айлджээ.

Бурхан багшийн сургааль ёсоор "Хаан гэмт хэргийг шүүхдээ энэрэнгүй, нигүүлсэнгүйг үзүүлэх хэрэгтэй. Бүхнийг саруул тунгалаг оюун ухаанаар тунгаахдаа таван зарчмыг баримтлах ёстой гэж номлодог. Үүнд:

Нэгдүгээрт, тэрбээр бодит байдалд тулгуурлах ёстой.

Хоёрдугаарт, хаан хүч чадал, эрх дархтай байхдаа шийтгэл оноох хэрэгтэй. Тэгвэл шийтгэл нь жинхэнэ цээрлэл болно. Хэрэв хааны хүч чадал, эрх дарх буурч суларсан байвал шийтгэл нь эмх замбараагүй байдлыг буй болгоно. Тиймээс дахин хүч чадал, эрх дархтай болтлоо хүлээх хэрэгтэй.

Гуравдугаарт, хэргийг шүүх үедээ гэмт хэргийн үр дагаврыг бус, харин түүнийг өдүүлсэн санаа бодлыг харгалзан үзэх хэрэгтэй. Гэмт этгээдийн сэтгэлийн гүн рүү харж, хэргийг санаатай эсхүл болгоомжгүй үйлдсэн эсэхийг тогтоох ёстой. Хэрэв санаандгүй үйлдсэн байвал түүнийг өршөөвөл зохино.

Дөрөвдүгээрт, хэрэгтэн этгээдтэй зөөлөн харьц, хэрхэвч бүдүүлэг загнаж болохгүй. Энэ нь гэмт хэрэгтэн ямар хууль зөрчсөнийг үнэн зөв тогтоож, түүнийг хэтрүүлж хилсдүүлэхгүй байхад хэрэгтэй юм. Түүгээр ч зогсохгүй, түүний сэтгэлийг халамжтай сайхан үгээр уярааж, үйлдсэн хэрэгтээ гэмшиж, нүглээ наминчилтал нь зөөлрүүлэх хэрэгтэй.

Тавдугаарт, гэмт хэрэгтэнд энэрэнгүй, нигүүлсэнгүй ханд, түүнийг үзэн ядаж хэрхэвч болохгүй. Гэмт хэргийг үзэн ядахдаа хүнийг нь үзэн ядаж хэрхэвч болохгүй. Хэрэгтнийг гэмт явдал үйлдсэнд нь харамсан гэмшүүлэхийн тулд түүнд энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэл хэрэгтэй юм"⁶⁶ гэж сургасан нь өнөөгийн хүний эрхийг дээдлэх энэрэнгүй ёсны зарчимтай дүйж байна.

"Их бодь мөрийн зэрэг" хэмээх зохиолд ихэнх гэмт хэргийн субъектив шалтгаан болдог бусдын эд хөрөнгөнд шунах нүгэл, бусдыг хорлох сэтгэлийг үүсгэхийн нүглийн талаар сургасан нь шүүх ял оногдуулахдаа харгалзах ёстой гэмт хэрэгтнүүдийн хувийн байдалд шууд хамааралтай арван хар нүглийн хоёр нь юм. Энэ зохиолд бичсэнээр бусдын

эдэд шунахын нүгэлд:

- а/ зөвхөн "хувиа борлуулж довоо шарлуулах" гэсэн үзэлд толгойгоо мэдүүлэх
- б/ эд хөрөнгө хураах, баяжих асар их сэтгэл шунал
- в/ эд хөрөнгийг өөрийн болгосноор сэтгэл нэн ихээр тайвшрах, амрах
- г/ "Бусдын юмс минийх л байх ёстой" хэмээх бодол толгойноос нь үл салах
- д/ бусдын эд хөрөнгөнд шунахайрах, нүдээ худалдахаас ичиж зовохоо болих, энэ бүхэн өөрт болон өрөөлд хөнөөлтэй гэдгийг мэдрэх ухаанаа алдах зэрэг муу сэтгэл багтана.⁶⁷

Бусдыг хорлох сэтгэлийг үүсгэх нүгэлд "Их бодь мөрийн зэрэг" бүтээлд:

- а/ бусдыг үзэн ядах, энэ нь өөрт нь хор болох зүйл бусдад байна хэмээн үзэхээс үүдэн гарна.
- б/ бусдад хор хүргэх гэсэн сэтгэлээ барих чадвараа алдах
- в/ бусдыг бодохоос уур хилэн нь бадрах
- г/ түүнийг цохиод авах юмсан, алаад хаячих юмсан гэсэн муухай бодол өөрийн эрхгүй орж ирэх
- д/ бусдыг хорлох сэтгэлээсээ өчүүхэн ч ичиж зовдоггүй байх зэрэг хамаарна гэжээ.⁶⁸

"Бодь мөрийн зэрэг" хэмээх сударт Будда засаршгүй том нүглүүдийг тоймлон "Арван хар нүгэл" гэж томъёолжээ. Доктор О.Дагвадорж "Тэгэхээр гэмт явдлыг түүний анхдагч онолын үндэслэгч бол Будда мөн. Будда зайлшгүй том нүгэл хэмээх томъёолол дор гэмт хэргийн тухай онолыг боловсруулжээ. Тэрээр 2500 жилийн тэртээд гэмт явдал хэмээх ойлголтод амь таслах, эс өгснийг авах, буруу хурьцах, худал ярих, хууран мэхлэх гэсэн дөрвөн цааз зохиожээ" гэж бичжээ. Хүмүүний энэ чадвар бие, хэл, сэтгэлийн аль нэгээр илэрдэг. Ингэхээр гэмт явдал ч мөн адил бие, хэл, сэтгэл гурвын үйл юм. Буддистууд гэмт явдлыг үндсэн гурван ангид хамаарах үйл болгон авч үзсэн. Үүнд:

- а/ амь таслах
- б/ эс өгснийг авах /хулгайлах/
- в/ буруу хурьцах нь биеэр үйлддэг гэмт явдал юм.

Харин хэлээр үйлддэг гэмт явдалд худал ярих, хов ярих, доромжлох, гүтгэх гэмт үйл хамаарна.

Сэтгэлээр үйлдэх гэмт явдалд шунахайрах, үзэн ядах, хорон санаа агуулах, буруу үзэл бодолтой байх зэрэг хамаарна.

Бодь мөрийн зэрэг хэмээх сударт ял зэмлэлийн талаар тусгайлан өгүүлжээ. Гэмт үйлдлийн мөн чанар, хүнд хөнгөнийг харгалзан гэм буруутанд оноож болох цээрлэл нь аль нэг талаар чангарах, эсхүл зөөлрөх бодитой нөхцөлийг бүрдүүлэх ёстой гээд гэм буруугийн байдлаас хамааран үр дагавар /ял/ нь хүндрэх дарааллыг ч дараах логикоор томъёолсон

⁶⁷ Иже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. СПб. 1994. 290-291 дэх тал

⁶⁸ Н.Хавх. Буддын гүн ухааны агуулгын харьцуулсан тайлбар. УБ.,2003. 433-435 дахь тал

⁶⁵ Монголын философийн түүх. УБ.,2001. 14 дэх тал

⁶⁶ Бурхан багшийн сургаал. УБ.,2000. 244-256 дахь тал

байна. Тухайлбал, амь таслах /алах/-1, эс өгснийг авах-2, буруу хурьцах-3, худал ярих-4, хов ярих-5, ширүүн үг хэлэх-6, чалчих-7, шунаг зан-8, үзэн ядах-9, буруу үзэл-10 хэмээн тоон дараалалд гэмт явдлыг оруулжээ. Ийнхүү энэ тооны дэс дарааллаар үйлдэл бүрийн хөнгөн ба хүндийн авч үзэж болох юм. Эдгээр үйл нь 1←2←3←4←5←6←7 гэсэн дарааллаар хүндрэх бол харин дараах үйл нь 8→9→10 гэсэн дарааллаар буюу цөөнхөөс их тоо руу хүндэрдэг гэж сударт тэмдэглэсэн байна. Гэмт хэргийн хор уршигт талыг харгалзан ангилах эрх зүйн үндэслэлийг ийнхүү тавьсан байна.

Энэ нь цаазын бичигт тодорхой гэмт явдлын зүйл, ангийн ялын төрөл, хэмжээг тогтоох, мөн шүүх, шүүгчийн зүйл ялын бодлогод алдаа гаргахгүй байх боломжийг хангах зорилготойг нотолж байна.

Гэмт хэрэг үйлдсэнээр тухайн хэргүүд ямар гэм хор /цээрлэл/ учирч болох талаар Будда номлосон байна. Тухайлбал, “Ямар ч гэм хоргүй амьтан, хүнийг зовоож байдаг хүн дараах 10 зүйлийн нэгийг заавал амсана. Үүнд:

1. Нүгэлт хүнд хаан дээдсээс шийтгэл ирнэ
2. Аймшигт ялд унана
3. Эрдэнэс баялгаасаа сална /торгууль авна/
4. Төрөл садангаасаа хагацна /шоронд орно/
5. Машид их тэсвэрлэшгүй зовлон амсана
6. Бие махбод, эрхтэн нь гэмтэнэ
7. Гүн сэтгэлийн шаналал амсана
8. Ухаангүй болно
9. Гэр орон нь гал түймэрт шатаж хувхайрна
10. Бие зовлого нь элэгдэж дуусаад эрлэг, тамд илгээгдэнэ”⁶⁹ гэж тодорхой заасан байна. Мэдээж гэмт хэрэг үйлдсэн хүмүүнд төрийн цаазаар ял шийтгэл хүлээлгэж, торгууль, төлбөрт эд хөрөнгө нь хураагдана, бас ах дүү, садан төрөл, танил хүмүүс нь хөндийрнө, ял эдэлбэл ганцаардаж, гэмшиж, шанална, бас сэтгэл санаа нь уймарч тогтворгүй болох бөгөөд сэтгэцийн өвчнөөр өвчлөх, муу зуршилд донтох магадлалтай, бас хүнд хөдөлмөрт талхигдан бие эрхтэн нь өвчилнө, хэврэгшинэ, эцсийн эцэст үхэх шалтгаан нь нэн эрт хуримтлагдана.⁷⁰

Их сэтгэгч, төв үзлийг үндэслэгч **Нагаржунай** “Төрийн удирдлага оновчтой, цэцэн мэргэн энэрэнгүй агуулгатай байх ёстой. Аливаа төрийн засаглал нь хүмүүст гагцхүү ял шийтгэл оногдуулаад зогсохгүй, тэдний оюун санаанд нь нөлөөлөн үйлчлэх ёстой”⁷¹ гэж сургасан.

Монголын эзэнт гүрний их хуульч **Шихихутугийн билиг сургаал** Монголын эрх зүйн сэтгэлгээнд том байр суурь эзэлдэг. Чингис хаан өргөмөл дүү Шихихутугаа “Бүх улсын доторх хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай” гэж бүх улсын дээд заргач /шүүгч/

болгосон байдаг. Шихихутуг насан өөд болтлоо Монголын төр, цааз эрхэмжийг бэхжүүлэх үйлсэд чин журмыг барин зүтгэж, эзэнт гүрэн даяар бишрэл хүндэтгэл хүлээх болжээ.⁷²

Ираны алдарт түүхч Рашид-Аддин “Тэр наян хоёр настайдаа заргыг шударгаар шүүж, ялтнуудад их тусалж, энэрч байжээ. Шихихутуг “Айж цочин хэрэг хүлээх хэрэггүй. Айлгүй үнэнээ хэл” гэж хэрэгтэн нарт зөвлөдөг байсан”⁷³ гэж бичжээ.

Далай лам Данзанжамц “Миний бие цаазаар авах ялын эсрэг байдаг бөлгөө. Энэ ялыг өмнөх далай лам Түвдэд устгасан юм. Өнөөдөр энэ ял Хятад, Энэтхэг зэрэг томоохон улс оронд оршсоор байгаа нь надад итгэмээргүй санагддаг. Тэр шударга ёс хэмээх нэрэн дор Махатма Гандийн эх оронд хүмүүсийг талсаар байна. Тэр нутагт Бурхан Буддагийн сургаалыг номолж байсан ариун газар шүү дээ. Цаазаар авах ял нь цэвэр хүчирхийлэл бөлгөө. Тэр ч бүү хэл, онц аюултай, яагаад гэвэл, бүх хүчирхийллийн нэг адил хүчирхийллийн бусад хэлбэр рүү хөтөлдөг ажгуу. Хамгийн дээд хэмжээний шийтгэл бол зэрлэг балмад явдалгүй, бүх насаар нь хорих ял байх ёстой”⁷⁴ гэжээ.

“Хууль зөрчсөн аливаа үйлдэл /гэмт хэрэг/ хийсэн хүмүүс ихэнх тохиолдолд нийлмэл тусгаарлагдаж шоронд хоригдоход хүрдэг. Тэд нийгмийн тогтолцооны шаар шавхруу мэт тооцогдож, нийгэм бүхэлдээ тэднээс нүүрээ буруулдаг. Ийм нөхцөлд хоригдлууд өөрийн гэм бурууг хүлээх хийгээд өөрийгөө төгс төгөлдөржүүлэх ямар ч боломжгүй юм. Гэмт хэрэгтэн хэмээн тооцогдох тийм үйлдэл хийсэн хүмүүсээс нийгэм нүүрээ буруулах учиргүй. Тэд бидний л нэгэн адил хүмүүс шүү дээ. Үүнээс гадна хөгжих, засрах чадвартай бол нийгмийн нэгэн гишүүн билээ. Тийм хүмүүнд итгэл олоход нь тусалж, амьдралыг нь зөв зам руу оруулах тал дээр зайлшгүй дэмжих шаардлагатай. Иймд шүүхүүд гэмт хэрэг үйлдсэн зарим хүмүүсийн хэргийн байдал, хувийн зан чанарыг харгалзан хорьж цагдахаас өөр ял оногдуулахыг эрхэмлэвэл зохино”⁷⁵ гэж Далай лам энэрэнгүй үзлээр ханджээ.

⁶⁹ Богд Зонхав. Бодь мөрийн зэрэг. УБ.,2006. 120-130 дахь тал; Дармапада. УБ.,2005. 137-141 дэх тал

⁷⁰ О.Дагвадорж. Дурдсан зохиол. УБ.,2008. 120 дахь тал

⁷¹ Гүн ухааны товчоо. УБ.,1966. 127-128 дахь тал

⁷² Ж.Баярбаатар, Д.Лүндээжанцан. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.,1998. 67 дахь тал

⁷³ Рашид. Аддин. Судрын чуулган. I боть. 1994. 61 дэх тал

⁷⁴ Дээрхийн Гэгээн XIV Далай лам Данзанжамц. Шилмэл бүтээл. УБ.,2009. 314 дэх тал

⁷⁵ Дээрхийн Гэгээн XIV Далай лам Данзанжамц. Шилмэл бүтээл. УБ.,2009. 411-412 дахь тал